



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДИЗАЙНЫ МЭРГЭЖЛИЙН

“FINDE” КЛУБ

ТАНИЛЦУУЛГА

The First Industrial Designers - Find your own way!

БИДНИЙ ТУХАЙ

ШУТИС ҮТС-ийн үйлдвэрлэлийн дизайны Finde клуб нь 2018 оны 09 сарын 17-нд албан ёсны нээлт хийж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Үйлдвэрлэлийн дизайны анхны мэргэжлийн клуб бөгөөд мэргэжлээ сурталчлах, таниулах, оюутнуудын ур чадварыг сайжруулан хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилгоор нээгдсэн.

Клуб удирдсан багш: Ч. Ариун /ахлах багш/

Хамтарч ажилладаг багш: Ц. Батсайхан /салбарын эрхлэгч, дэд профессор/

Б.Мөнхзул / ахлах багш/


Ц.Мөнхмандах / ахлах багш/

Б. Дэлгэрцэцэг / ахлах багш/

2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд үйлдвэрлэлийн дизайны 1, 2, 3,5-р курсийн оюутнуудыг хамруулан нийт 70 орчим гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Манай хамт олон - THE FINDERS





Үйлдвэрлэлийн дизайнерууд машин, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тоглоом, сав баглаа боодол, тавилга гэх мэт үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний концепц санааг боловсруулдаг. Урлагийн онол, бизнесийн ухаан, инженерчлэлийг хослуулан хүмүүсийн өдөр тутам хэрэглэдэг бүтээгдэхүүнүүдийг бий болгодог.



1 | Зорилго

- Нэг хүсэл тэмүүлэл дор, идэвхтэй үйл ажиллагаагаар нэгдэн ур чадвараа бие даан хөгжүүлэх, амжилтанд хүрэх замд нь оюутан нэг бүрийг замчлах
- Үйлдвэрлэлийн дизайн мэргэжлийн онцлог, давуу чанарыг таниулах
- Бүтээлч, тасралтгүй суралцагч чанарыг төлөвшүүлэх
- Ирээдүйд чанартай боловсон хүчин бий болгох




2 | Зорилт

- Хичээлээс гадуур оюутан залуусын сонирхол хүслийн дагуу сургалт явуулах
- Оюутнууд хоорондоо мэдлэг солилцох, хамтарч ажиллах
- Нийгэмд чиглэсэн бүтээлч ажлуудыг зохион байгуулах
- Оюутнуудад тулгарсан асуудлыг баг хамт олноор зөвлөлдөн шийдэх
- Ур чадвараа хөгжүүлэн, багш оюутны хамтын ажиллагааг идэвхжүүлэх

**Дизайн бол нэг талаасаа урлаг,
нөгөө талаасаа хэрэглээ бөгөөд
урлагаас ялгагдах онцлог нь
тодорхой зорилгод чиглэж
асуудлыг шийдвэрлэхэд оршдог.**

—Someone Famous



03

**Бид юу
хийдэг вэ?**

“Дотоод уур амьсал, нэгдмэл байдал”



Хичээлийн шинэ жилийн элсэлт бүрийн дараа бид шинэ гишүүдтэйгээ танилцаж ойр дотно болох зорилгоор нэг өдрийг эрүүл агаарт үр бүтээлтэй, хөгжилтэй танилцах өдөрлөг зохион өнгөрүүлдэг билээ.



“2022 оны намрын танилцах өдөрлөг”



“Төгсөгчтэй ярилцах цаг”



Жил бүр уламжлал болгон үе үеийн төгсөгчдөөс урьж чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг хийдэг. Ингэснээр суралцагчид мэргэжилдээ илүү дурлан, цаашид улам хичээх хүсэл эрмэлзэл нэмэгддэг.



“Үйлдвэрлэлийн дизайн”
мэргэжлээрээ бахархах
сэтгэлийг төрүүлж, хамт олны
дулаан дотно уур амьсгалыг
бүрдүүлдэг учир бид
өөсдийн гэсэн малгайтай
цамц ба ханцуйгүй цамцийг
бүтээж жигдэрдэг.

“Урлахуйн ертөнц 2022”



Сургуулийн төрөл
бүрийн үйл
ажиллагаа, наадам,
үзэсгэлэнд хамт
олноороо идэвхтэй
оролцдог ба өөрсдийн
бүтээлээ дэлгэн
танилцуулдаг



“Ажлын байранд гарах бэлтгэлийг оюутан цагаас...”

- Клубийн гишүүдэд CV, PORTFOLIO бэлтгэх талаар зөвлөгөөг нээлттэй өгдөг
- Хичээлээс гадуур чөлөөт цагаараа гишүүд нэгдэн спорт, урлагийн чиглэлээр хичээллэж багийн ажиллагаанд суралцдаг.
- Тогтмол чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлж оюутанд өөрийгөө нээлттэй илэрхийлж сурах боломжийг нээж өгдөг.
- Мэдлэг, мэдрэмж тэлэх сонирхолтой баримтат болон уран сайхны кино үзэх цаг
- Мэргэжилтэй холбоотой цагийн ажлыг гишүүдэд зуучлан туршлага хуримтлуулах
- Тухайн цаг үед зохион байгуулагдаж буй хурал хэлэлцүүлэг, гарч буй үзэсгэлэнг үзэх гэх мэт идэвхтэй үйл ажиллагаатай.





FINDE CLUB-т тавтай морил!

Үйлдвэрлэл хөгжихийн төлөө!

The First Industrial Designers - Find your own way!